



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/12/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Аудитор: Ж.Бүжинханд
Утас: Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди-Аудит ХХК
Захирал: Д.Эхбаяр
Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага	18
5.2 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НА	Нотлох ажил
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЭСҮТ	Эмгэг судлалын үндэсний төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТҮЭМ	Төрийн үйлчилгээ, эрүүл мэнд



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ГАНХҮҮ ТАНАА

2024.02.23 № 07/322
танай _____ -ныг № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд үйл ажиллагааны эсийн шинжилгээний тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлснээр байгууллагын санхүүгийн нөөц нэмэгдэж, эмч эмнэлгийн ажилчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, ажиллах орчин нөхцөл сайжирсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 295,776.8 мянган төгрөгийг цалин урамшуулал, урсгал засвар, эд хогшил худалдан авах зэрэгт зарцуулж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын үзүүлж байгаа эмгэг судлал, эсийн шинжилгээтэй холбоотой төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх асуудлыг тодруулаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-67.Docx

0001050632

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Handwritten signature

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,819,433.37	534,389,583.41
33	АВЛАГА	-	502,981,000.00
33500	Бусад авлага	-	502,981,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	502,981,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,819,433.37	31,408,583.41
35100	Түүхий эд материал	47,000,080.96	28,874,256.00
35110	Тусгай зориулалттай материал	47,000,080.96	28,874,256.00
35400	Хангамжийн материал	2,819,352.41	2,534,327.41
35410	Бичиг хэргийн материал	558,150.00	1,510,000.00
35420	Аж ахуйн материал	1,867,033.00	1,003,790.00
35440	Түлш, шатах тослох материал	394,169.41	20,537.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,621,012,530.12	1,596,449,508.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,621,012,530.12	1,596,449,508.60
39200	Биет хөрөнгө	1,619,352,144.59	1,595,190,748.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	594,090,200.00	689,672,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-67,125,951.36	-86,525,283.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,239,373.00	189,506,779.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,525,848.08	-44,528,846.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,301,060,939.79	1,232,781,565.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-394,281,371.88	-434,585,392.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,197,070.00	92,554,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,302,266.88	-43,684,694.67
39300	Биет бус хөрөнгө	1,660,385.53	1,258,760.53
39301	Програм хангамж	2,535,000.00	2,535,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-874,614.47	-1,276,239.47
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,670,831,963.49	2,130,839,092.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,670,831,963.49	2,130,839,092.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,670,831,963.49	2,130,839,092.01
51100	Засгийн газрын оруулсан капитал	368,401,756.70	368,401,756.70
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	368,401,756.70	368,401,756.70
51200	Хуримтлагдсан үр дүн	1,038,073,296.64	1,498,080,425.16
51210	Өмнөх үеийн үр дүн	461,228,869.24	1,038,073,296.64
51220	Тайлант үеийн үр дүн	576,844,427.40	460,007,128.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,356,910.15	264,356,910.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,670,831,963.49	2,130,839,092.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,320,858,910.63	3,770,193,679.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,199,922,906.63	1,400,169,927.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,199,922,906.63	1,400,169,927.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	422,480,430.00	1,179,359,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	422,480,430.00	1,179,359,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	736,244,527.86	195,772,974.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	41,197,948.77	25,037,853.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,120,936,004.00	2,370,023,752.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,642,135,400.00	1,898,522,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,642,135,400.00	1,898,522,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	478,800,604.00	471,501,352.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,689,904.00	67,987,552.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	377,110,700.00	388,243,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,744,014,483.23	3,310,186,551.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,744,014,483.23	3,310,186,551.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,335,418,968.98	2,630,070,845.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,265,958,519.75	1,482,420,732.34
210101	Үндсэн цалин	783,674,840.99	910,795,769.26
210102	Нэмэгдэл	258,675,281.49	333,297,716.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	106,045,800.00	104,670,368.50
210104	Урамшуулал	117,562,597.27	133,656,877.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,010,564.59	200,243,627.38
210201	Тэтгэврийн даатгал	128,480,340.16	125,610,871.11
210202	Тэтгэмжийн даатгал	9,090,867.06	15,102,772.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,105,286.10	29,090,808.09
210204	Ажилгүйдлийн даатгал	2,263,711.97	3,263,099.12
210205	Эрүүл мэндийн даатгал	23,070,359.30	27,176,076.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,259,639.00	86,763,048.00
210301	Гэрэл, цахилгаан	10,101,209.00	13,023,170.00
210302	Түлш, халаалт	12,182,718.00	10,348,278.00
210303	Цэвэр, бохир ус	38,885,712.00	51,963,600.00
210304	Байрны түрээс	9,090,000.00	11,428,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,331,791.73	47,358,000.00
210401	Бичиг хэрэг	9,275,970.00	11,182,240.00
210402	Тээвэр, шатахуун	9,553,693.00	10,686,568.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,132,261.96	2,850,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,895,770.00	17,960,111.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,474,096.77	4,679,081.00
2105	Нормативт зардал	417,869,178.64	376,165,790.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	401,901,318.64	350,166,790.36
210502	Хоол, хүнс	-	3,840,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,967,860.00	22,159,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,865,898.25	68,299,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,770,800.00	-
210604	Урсгал засвар	37,095,098.25	68,299,500.00
2107	Томиллолт, зочны зардал	6,999,800.00	26,140,300.00

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	6,999,800.00	26,140,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,390,853.00	67,418,891.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,426,879.00	48,724,171.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,762,150.00	12,042,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,512,988.00	1,772,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,400.00	119,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	109,384.00	49,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,734,152.00	4,403,170.78
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,601,900.00	308,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,732,724.02	275,260,955.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,553,758.20	19,592,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	10,972,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	194,178,965.82	244,695,995.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	408,595,514.25	680,115,705.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,999,813.00	229,897,188.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,524,545.00	79,809,990.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,475,268.00	150,087,198.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,595,701.25	450,218,517.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	255,748,908.49	450,025,510.52
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	846,792.76	193,007.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	576,844,427.40	460,007,128.52
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	576,844,427.40	460,007,128.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,543,416,434.00	3,046,401,852.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	422,480,430.00	676,378,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	422,480,430.00	676,378,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	422,480,430.00	676,378,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	422,480,430.00	676,378,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,120,936,004.00	2,370,023,752.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,642,135,400.00	1,898,522,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,642,135,400.00	1,898,522,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	478,800,604.00	471,501,352.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,689,904.00	67,987,552.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	377,110,700.00	388,243,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,520,532,434.00	3,022,041,852.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,520,532,434.00	3,022,041,852.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,111,936,919.75	2,341,926,146.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,265,206,726.94	1,482,420,732.34
210101	Үндсэн цалин	783,773,658.19	911,009,348.03
210102	Нэмэгдэл	258,297,632.06	333,269,356.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	105,565,433.23	104,670,368.50
210104	Урамшуулал	117,570,003.46	133,471,658.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,749,944.40	200,243,627.38
210201	Тэтгэврийн даатгал	128,325,102.54	126,036,946.51
210202	Тэтгэмжийн даатгал	12,694,248.67	15,102,772.51

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	20,451,564.83	29,139,056.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,345,857.10	2,788,775.30
210205	Эрүүл мэндийн даатгал	22,933,171.26	27,176,076.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,259,639.00	86,763,048.00
210301	Гэрэл, цахилгаан	10,101,209.00	13,023,170.00
210302	Түлш, халаалт	12,182,718.00	10,348,278.00
210303	Цэвэр, бохир ус	38,885,712.00	51,963,600.00
210304	Байрны түрээс	9,090,000.00	11,428,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,594,521.96	39,738,379.00
210401	Бичиг хэрэг	9,157,120.00	5,586,080.00
210402	Тээвэр, шатахуун	6,168,300.00	9,483,190.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,572,261.96	2,850,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,198,900.00	16,498,410.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,497,940.00	5,320,699.00
2105	Нормативт зардал	415,622,990.00	333,631,858.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	398,176,120.00	307,632,858.00
210502	Хоол, хүнс	-	3,840,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,446,870.00	22,159,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,817,657.25	69,113,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,376,500.00	784,000.00
210604	Урсгал засвар	38,441,157.25	68,329,900.00
2107	Томилолт, зочны зардал	6,999,800.00	26,140,300.00
210702	Дотоод албан томилолт	6,999,800.00	26,140,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,103,766.00	71,610,741.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,667,292.00	48,724,171.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,762,150.00	12,042,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,512,988.00	1,772,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,400.00	119,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	109,384.00	49,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,361,052.00	4,403,170.78
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,447,500.00	4,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,581,874.20	32,263,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,581,874.20	19,592,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	12,670,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	408,595,514.25	680,115,705.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,999,813.00	229,897,188.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,524,545.00	79,809,990.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,475,268.00	150,087,198.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,595,701.25	450,218,517.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	255,748,908.49	450,025,510.52
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	846,792.76	193,007.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,884,000.00	24,360,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,884,000.00	24,360,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,884,000.00	24,360,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,884,000.00	24,360,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,884,000.00	24,360,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,884,000.00	-24,360,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	461,228,869.24	1,093,987,536.09
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	461,228,869.24	1,093,987,536.09
7	Тайлант үеийн үр дүн	-	-	576,844,427.40	576,844,427.40
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	1,038,073,296.64	1,670,831,963.49
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	1,038,073,296.64	1,670,831,963.49
16	Тайлант үеийн үр дүн	-	-	460,007,128.52	460,007,128.52
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	1,498,080,425.16	2,130,839,092.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,215,299,200.00	2,124,874,989.48	90,424,210.52	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,215,299,200.00	2,124,874,989.48	90,424,210.52	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,134,213,000.00	2,044,032,339.48	90,180,660.52	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,499,909,300.00	1,427,317,647.07	72,591,652.93	95.2
210101	Үндсэн цалин	895,006,800.00	855,906,262.76	39,100,537.24	95.6
210102	Нэмэгдэл	383,444,800.00	333,269,356.87	50,175,443.13	86.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	92,400,000.00	104,670,368.50	-12,270,368.50	113.3
210104	Урамшуулал	129,057,700.00	133,471,658.94	-4,413,958.94	103.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,495,500.00	192,722,161.63	16,773,338.37	92.0
210201	Тэтгэврийн даатгал	128,308,900.00	121,123,111.74	7,185,788.26	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	15,095,200.00	14,592,881.05	502,318.95	96.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,882,100.00	28,215,620.02	4,666,479.98	85.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,019,000.00	2,628,623.17	390,376.83	87.1
210205	Эрүүл мэндийн даатгал	30,190,300.00	26,161,925.65	4,028,374.35	86.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,692,000.00	55,691,991.00	9.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	17,223,900.00	12,620,565.00	4,603,335.00	73.3
210302	Түлш, халаалт	11,670,000.00	10,348,278.00	1,321,722.00	88.7
210303	Цэвэр, бохир ус	18,286,700.00	23,795,148.00	-5,508,448.00	130.1
210304	Байрны түрээс	8,511,400.00	8,928,000.00	-416,600.00	104.9
2104	Хангамж, бараа материалын зардал	31,092,300.00	31,000,299.00	92,001.00	99.7
210401	Бичиг хэрэг	2,522,900.00	3,176,000.00	-653,100.00	125.9
210402	Тээвэр, шатахуун	5,451,400.00	5,450,860.00	540.00	100.0

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,162,900.00	2,850,000.00	312,900.00	90.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,955,100.00	16,498,410.00	1,456,690.00	91.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	3,025,029.00	-1,025,029.00	151.3
2105	Нормативт зардал	290,572,000.00	290,571,999.00	1.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	268,416,600.00	268,412,999.00	3,601.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,155,400.00	22,159,000.00	-3,600.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,057,500.00	10,057,500.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,307,900.00	8,307,900.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,749,600.00	1,749,600.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,336,100.00	2,328,300.00	7,800.00	99.7
210702	Дотоод албан томилолт	2,336,100.00	2,328,300.00	7,800.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,058,300.00	34,342,441.78	715,858.22	98.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,827,500.00	22,112,871.00	714,629.00	96.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,499,000.00	5,499,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	711,600.00	711,600.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,300.00	119,300.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,000.00	49,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,404,400.00	4,403,170.78	1,229.22	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,447,500.00	1,447,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,086,200.00	80,842,650.00	243,550.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,086,200.00	80,842,650.00	243,550.00	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,810,000.00	79,809,990.00	10.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,276,200.00	1,032,660.00	243,540.00	80.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,215,299,200.00	2,124,874,989.48	90,424,210.52	95.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,898,522,400.00	1,448,496,889.48	450,025,510.52	76.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,898,522,400.00	1,448,496,889.48	450,025,510.52	76.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	316,776,800.00	676,378,100.00	359,601,300.00	213.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	316,776,800.00	676,378,100.00	359,601,300.00	213.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70	70	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	52	52	-	
620003	Үйлчлэх ажилтан	17	17	-	
620004	Гэрээт ажилтан	0	0	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	471,501,352.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	471,308,345.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	322,253,807.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	55,103,085.27
210101	Үндсэн цалин	-	55,103,085.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	7,521,465.75
210201	Тэтгэврийн даатгал	-	4,913,834.77
210202	Тэтгэмжийн даатгал	-	509,891.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	923,436.49
210204	Ажилгүйдлийн даатгал	-	160,152.13
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,014,150.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	31,071,057.00
210301	Гэрэл, цахилгаан	-	402,605.00
210303	Цэвэр, бохир ус	-	28,168,452.00
210304	Байрны түрээс	-	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,738,080.00
210401	Бичиг хэрэг	-	2,410,080.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,032,330.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,295,670.00
2105	Нормативт зардал	-	43,059,859.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	39,219,859.00
210502	Хоол, хүнс	-	3,840,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	83,416,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	16,836,100.00
210604	Урсгал засвар	-	66,580,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	23,812,000.00
210702	Дотоод албан томилолт	-	23,812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	37,268,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	26,611,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	6,543,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,061,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	3,052,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	32,263,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,592,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	12,670,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	149,247,545.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	149,054,538.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	149,054,538.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	193,007.24
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	193,007.24
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	471,501,352.26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	471,501,352.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	67,987,552.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	388,243,800.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Эмгэг судлалын үндэсний төвийн эрхэм зорилгыг "Үйлчлүүлэгчийн хэрэгцээ ба хүлээлтэд нийцсэн эмгэг судлалын тусламж үйлчилгээг олон улсын стандартын дагуу нотолгоонд тулгуурлан үзүүлж, тасралтгүй сайжруулна" гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь улсын хэмжээний эмгэг судлалын амьд сорьц, эс судлал, нас барагчийн цогцсын шинжилгээ, оношилгооны үйл ажиллагааг мэргэжлийн хувьд нэгтгэн удирдаж, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулахад туслах зорилго бүхий цогцос шинжилгээ, эд эс судлалын, эд химийн, эсийн дэд түвшний оношилгоо, судалгаа шинжилгээний чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49,А/118 дугаар хамтарсан тушаал "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай"
- "Журам шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Захирлын 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 460,007.1 мянган төгрөгөөр буюу 27.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	502,981.0	502,981.0
Бараа материал	49,819.4	31,408.6	(18,410.8)
Үндсэн хөрөнгө	1,621,012.5	1,596,449.5	(24,563.0)
Нийт хөрөнгө	1,670,831.9	2,130,839.1	460,007.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,670,831.9	2,130,839.1	460,007.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,670,831.9	2,130,839.1	460,007.1

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 502,981.0 мянган төгрөг болж өссөн нь байгууллагаас авах 502,981.0 мянган төгрөгийн авлага бүртгэсэнтэй холбоотой;

Бараа материал дансны үлдэгдэл 31,408.6 мянган төгрөг болж 18,410.8 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалын зарцуулалтаас голлон шалтгаалсан;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,596,449.5 мянган төгрөг болж, 24,563.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 24,360.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн, үнэ төлбөргүй 195,773.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 2,823.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж, хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол 180,382.1 мянган төгрөг, тайлант онд тооцсон 61,490.4 мянган төгрөгийн элэгдлээс тус тус шалтгаалсан;

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 2,130,839.1 мянган төгрөг болж 460,007.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2023 оны төсвийн төсөлд улсын төсвийн санхүүжилтээр 2,028,227.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 300,000.0 мянган төгрөг, нийт 2,328,227.1 мянган төгрөгийг орлогыг

бүрдүүлж, нийт зарлагыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 112,927.9 мянган төгрөгөөр бууруулж, 2,215,299.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч дээд шатны байгууллагаас төсвийг шаардлагатай хэмжээнд баталж өгөөгүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал, харуул, хамгаалалтын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,898,522.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 316,776.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,448,496.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогод 676,378.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,124,875.0 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 89,466.1 мянган төгрөг, харуул, хамгаалалтын зардлын төсвийг 714.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 243.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71601-Нийгмийн эрүүл мэнд	2,215,299.2	2,124,875.0	90,424.2	95.9
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,114,586.0	2,025,119.9	89,466.1	95.8
2	80219- Харуул, хамгаалалтын зардал	19,627.0	18,912.5	714.5	96.4
3	80802: Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	81,086.2	80,842.6	243.6	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 67,987.6 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 388,243.8 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 15,270.0 мянган төгрөг нийт 471,501.4 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 322,253.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 149,054.5 мянган төгрөг нийт 471,308.3 мянган төгрөгийг зарцуулж, 193.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 1, шууд худалдан авалтаар 22 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар 399,912.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр 248,613.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, 151,299.1 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг шууд худалдан авалтыг хийж, худалдан авах ажиллагааны тайланг гаргасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах цалингийн тооцоолол, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 25-аас 2024 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Оюунцэцэг аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Насанжаргал, Захирал Д.Эхбаяр, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүү-нийцлийн газрын аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Б.Долгорсүрэн, захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, 1 хувиар буюу 27,440.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тендер болон цахим худалдан авалтаас хамгийн бага үнийн дүнтэй болон чанар ба үнэлгээний аргыг ашиглан хамгийн бага харьцуулах үнэтэй болон загвар дээжийг туршиж сонгон шалгаруулалт хийх, зах зээл дээрх бараа, ажил үйлчилгээнээс бага үнийн дүнтэйг сонгон ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгаагаар Эмгэг судлалын үндэсний төв нь суудлын 4 автомашинтай, улсын дугаар цэнхэр дэвсгэртэй, автомашинтай холбоотой 41,298.3 мянган төгрөгийн цалингийн зардал, 10,686.5 мянган төгрөгийн шатахууны зардал, 1,846.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээний зардал гаргасан, дуудлагын тээврийн хэрэгсэл ашиглахгүй, тэргүүн дэд, орлогч дарга, зөвлөх ажилладаггүй, цахим дэлгүүрээс 17,749.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт шалгалт хийхэд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс нийт 47 мэдээллийг мэдээлэхээс 42,433.1 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;-гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 490.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерийн Багц 2-т шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй нь тендерийн баталгааг улсын орлого болох үндэслэл болсон бөгөөд тендерийн баталгааг улсын орлого болгоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно”, 20.7.2-т “«хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Тайлант хугацаанд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендер ирүүлсэн оролцогчдын материалыг чанар ба үнэлгээний аргаар үнэлээгүй, Багц 2-т шалгарсан Етемо ХХК-ийн 100,615.3 мянган төгрөгийн гэрээний үнийн дүнгээс тендерийн гүйцэтгэлийн баталгааг аваагүй, тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх талаар тусгаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 28 дугаар зүйлийн 28.7.5-д “эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ”, 43 дугаар зүйлийн 43.4-т “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана”, 43.4.2-т “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах”, 46 дугаар зүйлийн 46.1.2-т “үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах”, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалын 3.2-т “Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

хууль, Авлигын эсрэг хуульд заасан эрх эдэлж үүрэг хүлээх ба худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөнө” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн гүйцэтгэлийн баталгаа аваагүй, тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх талаар тусгаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Шилэн дансны болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, 8 дансны хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан бөгөөд аудитаар нийт 165,180.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 64,074.2 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгасан. Биелэлт хангалтгүй 101,106.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 952,995.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар өгсөн 859,325.6 мянган төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжилт 100 хувь, 93,670.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	859,325.6	2	859,325.6	100
Зөвлөмж	5	93,670.2	3	93,670.2	60
Нийт дүн	7	952,995.8	5	952,995.8	80

Байгууллагын дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй нийт 31 төрлийн 44 ширхэг 183,205.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байсан зөрчлийг арилгах болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандарт, заавар, журам, бүртгэл хөтлөх арга зүйтэй нийцүүлэн НБББББ-г боловсруулж батлан мөрдөх талаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

